



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 19 өдөр

Дугаар А/429.

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 3/02 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. ОХУ-ын нийслэл Москва хотод зохион байгуулагдсан Муслим Магомаевын нэрэмжит олон улсын дуурийн дуулаачдын VI уралдааны зардлын дэмжлэгт Соёлын тэргүүний ажилтан Б.Гомбо-Очирт 5 000 000 төгрөг, Олон угсаатны магтуу дууны чуулбар бүтээлийг бүтээж туурвисан Болор цомын эзэн яруу найрагч М.Отгонбаярт 2 000 000, Соёлын тэргүүний ажилтан Ш.Баянмөнхөд 1 000 000 төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт зарцуулагдах 8 000 000 төгрөг /найман сая/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.5-д тусгагдсан “Олон үндэстэн ястны өв соёл урлаг” арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Дэлгэрсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ